



EAC ХХК-Д

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ХОТ БАЙГУУЛАЛТ,  
ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР**

Наадамчдын зам 1200, Арцатын ам,  
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот, 17100  
Утас: (976) 7270 7700  
Цахим хуудас: [www.uda.ub.gov.mn](http://www.uda.ub.gov.mn)

2024.09.24 № 01/0185  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонсох ажиллагааны мэдэгдэл  
хүргүүлэх тухай**

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/27 дугаар тушаалаар Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо Богдхан уулын дархан цаазат газрын тусгай хамгаалалттай газар нутаг, Арцатын ам (17100) бүсчлэл нутаг дэвсгэрт Аялал жуулчлалын зориулалтаар “ЕАС” ХХК-д олгосон 0.37 га газрыг үндэслэн 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдөр МЗХ2017/17-28 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар, 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Загвар зургийг тус тус баталсан байна.

Иргэн Г.Отгондалай, Г.Гандэлгэр нарын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр гаргасан өргөдөл, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 270 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/229 дугаар тушаалыг тус тус үндэслэн Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх “хууль, захиргааны хэм хэмжээний актаар, эсхүл захиргааны актад түүнийг хүчингүй болгохоор заасан;” заалт, Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх “барилгын үйл ажиллагаанаас шалтгаалан үүсэх иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх, ашиг сонирхол;” заалт тус тус баримтлан 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдөр МЗХ2017/17-28 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар, 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Загвар зургийг тус тус хүчингүй болгох асуудлаар Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.4.2 дахь заалтад заасан хэлбэрээр сонсох ажиллагаа явуулж байна. Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол -т бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломжтой тул

1750021276

холбогдох бичиг баримтыг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор албан бичгээр ирүүлэхийг мэдэгдэж байна.

Жич:Товлосон хугацаанд тайлбар, мэдээлэл ирүүлээгүй тохиолдолд Захиргааны шийдвэрийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Мэдээлэл авах утас: Хуулийн хэлтэс 72707700.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ТӨГСДЭЛГЭР